

# 11

## АНГЛИ ХЭЛИЙГ СУРАХАД СУРАЛЦАГСДЫН НАС НӨЛӨӨЛСӨН ТАЛААР СУДАЛСАН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Л.Энхмэнд

**Хураангуй-** Манай оронд англи хэлний хэрэглээ улам бүр нэмэгдэж, бүх шатны сургуулийн англи хэлний сургалтын хөтөлбөр, заах арга зүйг боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байгаа ондоо үед, гадаад хэлийг сурахад нөлөөлөх хүчин зүйлс, ялангуяа суралцагчдын нас, танин мэдэхүйн үйлийн онцлогуудыг судлан тогтоож, сургалтандаа харгалзан үзэх нь судлаач эрдэмтдийн нэг чухал зорилт болж байна. Иймээс бид гадаад хэл сурахад суралцагсдын нас хэрхэн нолоолж байгаа талаар судалсан судалгааны дүнг авч үзэж байна.

**Түлхүүр үг - гадаад хэлийг сурахад нөлоолох хүчин зүйлс, тохиромжтой насны бүлэг, загвар судалгаа, туршилтын судалгаа, асуулгын арга, хэл сурах үйл явц, мэдээлэл боловсруулах програм, судалгаанд хамрагсад, авиан дуудлага, хэл зүйн дүрэм, зорилтом хэлийг ашиглах өронхий чадвар, бага насныхан, освор насныхан, насанд хүргсэд**

### Судалгааны зорилго:

Англи хэлийг сурахад суралцагсдын нас хэрхэн нөлөөлж байгаа талаар анхны судалгааг 2006 онд хийсэн бэгоод уг судалгааны зорилго нь гадаад хэл түүний дотор Англи хэл суралцагсдын хувьд уг хэлийг судалж эхэлсэн нас тэдний сурах үйл явц болон амжилтанд хэрхэн нөлөөлсөн байдал, гадаад хэлийг тодорхой наснаас хойш сурвал гарах хүндрэлүүд болон гадаад хэл сурахад амжилт үзүүлэх тодорхой үе гэж байдаг бол хэдэн нас байх вэ зэрэг асуултуудад хариулт авч, Монгол орны хувьд гадаад хэл сурах хамгийн тохиромжтой насны бүлгийг тогтоох явдал байлаа.

**Туршилтын судалгаа:**

Судалгааны төлөвлөгөө, загвар, асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараа асуулгын зохиомж бүтэц агуулгыг хянах зорилгоор туршилтын судалгааг 2006 оны 2,3,4-р саруудад нийт дунгэрээр 430 гаруй хүнээс 4 янзын өөр асуулгын хуудсаар авсан. Туршилтын судалгааны эцсийн үр дүн болон мэдээлэл боловсруулах програмын туршилтын дунд судалгааны асуулгыг дахин хянаж, засварлан зарим шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан асуулгыг эцэслэн боловсруулав. Хоёр дахь шатны судалгааг 2 үе шаттайгаар явуулсан. Эхний шатанд 2007-2008 оны хичээлийн жилд МУИС-н ЭЗС-н 1 курсын 327 оюутнуудаас хичээлийн жилийн эхний өдөр Англи хэлний C-test буюу Англи хэлний мэдлэгийн түвшинг тогтоох шалгалт авч түвшингээр нь Англи хэлний 13 группид хуваарилан сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу явуулж хичээлийн жилийн эцэст Еронхий Англи хэлний эцсийн шалгалтын дүнтэй харьцуулан суралцагсдын амжилтыг судалсан болно. Хоёр дахь шатны судалгааг 2007-2008 оны хичээлийн жилийн эцэст ЭЗС-н 1 курсын 220 оюутнуудаас асуулгын аргаар тэдний Англи хэл сурх явцад суралцагсдын гадаад хэл судалж эхэлсэн нааснаас гадна багшийн заах арга барил, хэл сурх орчин, сургалтын хэрэглэгдхүүн болон суралцагсдын хэл сурх авьяас, идэвх оролдлого хэрхэн нөлөөлж байгаа байдал болон уг хэлийг монгол багш болон гадаад багшаар заалгах нь ямар ялгаатай байгаа зэргийг тодруулахыг зорьсон. Мөн англи хэлний хичээлийг түвшингээр нь групп болгон хичээллэснээр тэдний хэл сурх явцад хэр ахиц гарсаныг тодруулахыг зорьсон.

**Мэдээлэл боловсруулалт:**

Цуглуулсан асуулгын хуудсуудыг хянах засварлан нохсон асуулгын хуудсуудыг компьютерт шивэх болон мэдээлэл боловсруулалт хийх ажлыг Математик-статистикийн боловсруулалт хийх SPSS болон Excel программуудыг ашиглан гүйцэтгэв.

**Судалгаанд хамрагдлалт:**

Уг судалгаанд маш өргөн хүрээний хүмүүсийг хамруулсан. Үүнд:  
**1. Торийн болон хувийн хэвшлийн дунд сургуулийн 92 сурагч:** Орчлон сургуулийн - 19, Hobby сургуулийн - 17, King's kids сургуулийн -20, 10 жилийн 23-р сургуулийн -19, 10 жилийн 1-р сургуулийн -17 сурагчид оролцсои бөгөөд тэд 5-11-р ангиудад суралцаж байсан.

**2. Улсын болон хувийн их, дээд сургуулийн 284 оюутан:**

Оюутны судалгаанд МУИС ЭЗС-н 1 курсын -38, ФЭС Цаг уурын 2 ангийн -19, Магистр Докторын - 72 оюутан, ГХСС Англи хэлний 3 -р курсын - 5, 4 курсын -11 Герман хэлний 4 курсын - 5, ЭЗС-н Санхүү Ня-бо ангийн оройн 2,5 жил -17, ХУИС Англи хэлний 4 курсын -17, Боловсролын ИС Англи хэлний 4 курсын - 18, ШУТИС ГХС Англи хэл-техникийн орчуулагчын 4 курсын -20, Отгонтэнгэр ИС-н Англи хэлний 4 курсын -20, Орхон ИС Англи хэлний 4 курсын -20, Удирдлагын Академийн Бизнес болон Төрийн Удирдлагын Өдрийн Гарагийн ангиудын - 19 оюутнууд оролцлоо. Үүнээс Бакалаврын түвшний -209 (72,1%),

Магистрын түвшний -57 (19.7%), Докторын түвшний – 18 (6.2%) оюутан оролцсон байна. Судалгаанд оролцсон нийт 284 оюутнаас 234 оюутан буюу 80.7% нь Монгол хэлээр, 53 оюутан буюу 18.3% нь Англи хэлээр санал асуулгыг бөглөсөн байна.

**3. Торийн өмчтэй ба хувийн их, дээд сургуулийн болон дунд сургуулиудийн 33 гадаад хэлний багш нар**

Гадаад хэлний багш нарын дийлэнх буюу -26 нь 78,8% Англи хэлний хичээл заадаг байсан. 11 багш Их, Дээд сургуулиудад, 22 нь дунд сургуульд ажиллаж байсан байна.

Түүнчлэн бидний судалгаанд Монгол улсын боловсрол, эрүүл мэнд болон байгал орчны салбаруудад ажиллаж байсан АНУ-н сайн дурын 50 мэргэжилтэн оролцсон бөгөөд тэдэнд тусгайлан бэлтгэсэн асуулт гарган тэдний гадаад хэл судалж эхэлсэн нас тэдний хэл сурх амжилтанд хэрхэн нөлөөлсөн талаар судалсан. Уг сайн дурын мэргэжилтнүүд манай улсад 2005 оны 6 сард ирээд 3 сарын турш монгол хэл заалгасан байна. Судалгаанд хамрагсад нь 22-с 74 наасны 28 эмэгтэй, 22 эрэгтэй байлаа.

**Судалгаанд хамрагсдын ерөнхий шинж:**

Энэ хэсэгт бид судалгаанд хамрагсдын наасны бүлэг, боловсролын түвшин, наасанд хүрэгсдийн хувьд ажил эрхэлж буй салбар, хэдэн гадаад хэл мэддэг болон хамгийн сайн эзэмшсэн хэл зэргийг гаргалаа.

Хүснэгт 2.1 Судалгаанд хамрагсдын наасны бүлэг

Насны бүлэг	Дунд сургуулийн суралцагсад		Их Дээд сургуулийн суралцагсад		Англи хэлний багш нар	
	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent
10-14	31	33,7%				
<b>15-18</b>	<b>59</b>	<b>64,1%</b>				
17-19	2	2,2%	68	23,9%		
<b>20-25</b>			<b>147</b>	<b>51,8%</b>	<b>7</b>	<b>21,2</b>
<b>26-30</b>			49	17,3%	<b>13</b>	<b>39,4</b>
31-35			10	3,5%	5	15,2
36-40			7	2,5%	4	12,1
40 –с дээш			3	1,1%	4	12,4
Totals	92	100%	284	100%	33	100%

Дунд сургуулийн суралцагсын 64,1% буюу 59 сургач 15-18 насыхан, Их Дээд сургуулийн оюутнуудын 51,8% буюу 147 оюутан 20-25 насыхан байгаа нь Бакалаврын оюутнуудыг илүүтэйгээр оруулснаас болсон. Монголын боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш нар ихээхэн залуужсан нь бидний судалгаанд оролцсон 33 багшаас 13 буюу 39,4% нь 20-30 насыхан байгаа нь харуулж байна. Насны олон бүлгийг хамруулсан нь янз бүрийн насны хүмүүс өөрсдийн гадаад хэл сурх амжилтыг хэр үнэлж байгаа, тэдний гадаад хэл сурч эхэлсэн нас яж нөлоөлсөн болон Х2-г оройтож сурх боломж байгаа эсэх, гарах хүндрэлүүдийг насны бүлэг бүрийн хүмүүс юу гэж үзж байгааг олж тогтоохыг зорьсон болно.

Хүснэгт 2.2

Судалгаанд оролцогсдын мэргэжлийн бүлэг

Мэргэжлийн бүлэг	Frequency	Valid Percent
Боловсролын байгуулгад ажиллагсад	62	15,1
Эдийн засгийн мэргэжилтнууд	37	9,0
Байгалин ухааны салбарт ажиллагсад	17	4,1
Инженер техникийн ажиллагсад	6	1,4
Нийгмийн ухааны салбарт ажиллагсад	22	5,3
Оюутнууд	173	42,2
Сургачид	92	22,4
Total	409	100,0

Оюутнаас авсан судалгаанд янз бүрийн насны Бакалавр, Магистр, Докторын түвшний сургалтанд хамрагдаж байсан хүмүүсийг хамруулсан учраас тэдний мэргэжлийн бүлгийг гаргаж аль мэргэжлийн хүмүүс Магистр болон Докторын шатны сургалтанд илүү хамрагдаж байгааг гаргах боломжыг олгосон. Үүнд Боловсролын байгууллага болон Эдийн засгийн мэргэжлээр ажиллаж байгаа хүмүүс илүүтэйгээр Дипломын дараах сургалтанд хамрагдаж байсан. Өөр бусад салбарт ажиллаж байсан хүмүүсийн хувьд МУИС-н ЭЗС-н өдөр, орой болон Удирдлагын Академийн Бизнес ба Төрийн Удирдлагын Өдрийн Гарагийн Бакалаврын зэрэг олгох ангиудын оюутнууд оролцсон нь бусад мэргэжлийн бүлгийн хүмүүсийн 11% хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2.3

Судалгаанд хамрагдсын эзэмшсэн гадаад хэлний тоо

Эзэмшсэн гадаад хэл	Дунд сургуулийн суралцагсад		Их Дээд сургуул ийн суралцагсад		Англи хэлний багш нар	
	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent
1 хэл	35	38	117	41,2	10	30,3
2 хэл	44	47,8	134	47,2	21	63,6
3 хэл	10	10,9	28	9,9	2	6,1
4 хэл	3	3,3	3	1,1		
5хэл			2	,7		
Total	92	100	284	100	33	100

Манай орны хувьд 1990 оноос хойш орос хэлээс гадна өөр бусад гадаад хэлийг сурх явдал ихээхэн түгээмэл болсон нь өнөөгийн зах зээлийн болон глобальчлагдаж буй нийгэмтэй салшгүй холбоотой билээ. Х2 сурх нь ихэнх залуучуудын хувьд амьдралын ирээдүйн баталгаа болж байгаа учраас гадаад хэл сурх явдал нэмэгдсээр байна.

Судалгаанд оролцсон 409 хүний 199 буюу 48,6% нь 2 гадаад хэл эзэмшсэн гэж үзж байгаа нь ихэнх оюутнууд дунд сургуульд орос хэлийг заавал сурх хэл болгон үзж байсантай холбоотой юм. 3-с дээш хэл мэддэг 46, нэг Х2 хэлийг эзэмшсэн гэж үзж байгаа 162 – 39,6% байна. Гэвч судалгаанд оролцогсдын дийлэнх хувь нь /211 -51,5% / хэлний бус мэргэжлийн ангийн оюутнууд байсныг харгалзвал зохильтой.

Хүснэгт 2.4

Судалгаанд хамрагдсын хамгийн сайн эзэмшсэн гадаад хэл

	Дунд сургуулийн суралцагсад		Их Дээд сургуул ийн суралцагсад		Англи хэлний багш нар	
	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent
Англи	77	83,7	179	63	26	78,8
Орос	10	10,9	63	22,2	6	18,2
Япон	2	2,2	11	3,9	1	3,0
Солонгос			7	2,5		
Герман	2	2,2	10	3,5		
Хятад	1	1,1	2	,7		
Польш			2	,7		
Франц			5	1,8		
Турк			5	1,8		
Totals	92	100	284	100	33	100

Англи хэлийг судалгаанд оролцогсдын 68,9% буюу 282 хүн бусад хэлээс илүү сайн эзэмшсэн гэж үзэж байхад орос хэлний эзлэх хувь 19,3% байгаа нь хэдийгээр олон жилийн турш уг хэл нь заавал судлах ёстой Х2 байсан боловч хэрэглээ багассанаас сурх сонирхол эрс буурсныг харуулж байна. Их, Дээд сургуульд суралцагсад Англи, Орос хэлээс гадна Япон, Солонгос, Герман, Франц болон Турк хэлиүүдийг сайн эзэмшсэн гэжээ. Багш нарын хувьд дийлэнх нь Англи хэлний багш нар байсан учраас 78,8% нь уг хэлийг мэргэжлийн түвшинд сурсан байна.

Хүснэгт 2.5

Дунд сургуулийн сурагчид болон Англи хэлний багш нар хамгийн сайн эзэмшсэн гадаад хэлээ ямар хэмжээнд сурсан гэж үздэг талаар

Дунд сургуулийн сурагчид	Frequency	Valid Percent	Англи хэлний багш нар	Frequency	Valid Percent
Орчуулга хийх Хичээлийн хөтөлбөрийн хэмжээнд Уран зохиолын ном уншиж ойлгох	13 58 21	14,1 63,0 22,8	Орчуулга хийх Хичээлийн хотолборийн хэмжээнд Уран зохиолын болон ШУ-ны ном зохиол уншиж хэмжээнд Орчуулга хийх, уран зохиолын болон ШУ ном уншиж ойлгох	4 6 5 18	12,1 18,2 15,2 54,5
Total	92	100,0	Total	33	100,0

Дунд сургуулийн суралцагсдын 63% нь англи хэлийг хичээлийн хөтөлбөрийн хэмжээнд сурсан гэж үзэж байхад Англи хэлний багш нарын 54,5% нь орчуулга хийх, уран зохиолын болон ШУ ном уншиж ойлгох болон мэргэжлийнхээ дагуу эзэмшсэн гэж хариулцгаасан байна.

#### Судалгааны үр дүн:

Гадаад хэл суралцаж эхлэхэд суралцагсдын нас хэрхэн нөлөөлж байгааг судлах нь Монгол орны хувьд гадаад хэлний сургалтын бодлогыг зөв тодорхойлох, хичээлийн агуулга хөтөлбөр зэргийг тодорхой насын бүлэгт тохируулан ялгавартай боловсруулах зайлшгүй хэрэгцээ юм. Одоогийн сургалтын практик дунд сургууль болон Их дээд сургуулиудад ч гэсэн Англи хэлний хичээлийг багш бүр өөрийн гэсэн хөтөлбөрөөр, өөрт байгаа сурх бичгээр зааж байгаа нь

бага, дунд аngiul болон гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай аngiud ч гэсэн ижил сурх бичиг, сургалтын материалыг ашиглахад хүргэж байна. Цаашид их дээд сургуульд ороод ч ихэнхдээ хуучин сурх бичгийг ашиглаж урд нь сурх байсан нэг л зүйлээ давтан заалгасаар Англи хэлний мэдлэг нь гүнзгийрэхгүй тэднийг залхаах хандлагатай болж байна. Үүний хор уршиг нь нийт төгсөгчдийн Англи хэлний мэдлэг харьцангуй доогуур үнэлгээтэй гарч ажил олгогчдын тавьж буй шаардлагыг хангахгүйд хүргэж байна.

Иймээс гадаад хэл зааж эхлэх хамгийн тохиромжтой насын бүлгийг тогтоон бүх төрийн өмчит болон хувийн хэвшлийн сургуулиудад хамгийн зөв насыас нь эхлэн Англи хэлний хичээлийг хамгийн оновчтой хөтөлбөр төловлогөөний дагуу орчин үеийн хүргээжтэй сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан, чадвартай багш нараар заалгавал Англи хэлний сургалтын чанар эрс сайжирч бид суралцагчдын гайхалтай амжилтыг харах бололцоотой болно.

Хүснэгт 2.6

Дунд сургуулийн суралцагсдын гадаад хэл анх судалж эхэлсэн нас

Гадаад хэл суралцаж эхэлсэн нас	Дунд сургуулийн суралцагсад	
	Frequency	Valid Percent
4-9	47	51,1
10-14	39	42,2
15-с дээш	6	6,5
Total	92	100,0

Хувийн хэвшлийн дунд сургуулиудад Англи хэлийг бага насыас нь эхлэн зааж байгаагаас манай судалгаанд хамрагдсан сурагчдын 51,1% буюу 47 нь 7 насыас, төрийн өмчийн сургуулиудийн 39 - 42,2% сурагч 12 насыас эхлэн хичээлийн хөтөлбөрийн дагуу сурх эхэлсэн гэжээ. Харин 6 сурагч орос хэлний хичээлийг сурх байгаад 8 ангисаа Англи хэлийг судалсан гэж хариулсан байна.

Хүснэгт 2.7 Бусад судалгаанд хамрагсдын гадаад хэл анх судалж эхэлсэн нас

Гадаад хэл суралцаж эхэлсэн нас	Их Дээд сургуулийн суралцагсад		Англи хэлний багш нар		Монголд ажиллаж буй Америк мэргэжилтнүүд	
	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent	Frequency	Valid Percent
4-10 нас	30	10,6	4	12,1	4	8,0
11-17 нас	135	47,5	12	36,4	21	42,0
18-с дээш	119	41,9	17	51,5	25	50,0
Totals	284	100	33	100	50	100

Оюутнуудын хувьд 135 буюу 47,5% нь 11-17 насны хооронд заалгасан байхад 119 /41,9%/ нь 18 -с дээш наснаасаа сурч эхэлсэн гэжээ. Энэ нь 116 оюутан Англи хэлний мэргэжлийн ангийн оюутнууд байгаагаас болсон байна. Англи хэлний багш нарын 51,5% нь 18 -с дээш наснаас, 36,4% нь дунд сургуулийн хөтөлбөрийн дагуу 12 наснаас эхлэн уг хэлийг судалж эхэлжээ. Монголд ажиллаж байсан 22 -74 насны 50 Америк мэргэжилтнүүдийн 25% буюу 25 нь 18 -с дээш наснаасаа эхлэн гадаад хэлийг сурч эхэлсэн харин 21 нь 11-17 наснаасаа эхэлсэн гэж хариулсан байгаа нь АНУ-д бага наснаас нь эхлэн гадаад хэл заах нь тийм ч түгээмэл бус байгааг харуулжээ.

## Хүснэгт 2.8

Гадаад хэл сурч эхэлсэн нас хэл сурхамжилтанд нөлөөлсөн байдал

Нас хэр нөлөөл сөн	Дунд сургуулийн суралцагсад		Их Дээд сургуулийн суралцагсад		Англи хэлний багш нар		Монголд ажиллаж буй Америк мэргэжилтнүүд	
	Fre quency	Valid Percent	Fre quency	Valid Percent	Fre quency	Valid Percent	Fre quency	Valid Percent
Маш их	30	32,6	74	26,1	13	39,4	18	36,0
Зарим талаар	56	60,9	162	57,0	16	48,5	30	60,0
Огт нөлөө лөөгүй	6	6,5	48	16,9	4	12,1	2	4,0
Totals	92	100	284	100	33	100	50	100

Гадаад хэлийг бага наснаас нь зааж эхэлбэл амжилттай сайн сурдаг гэсэн ойлголт оновчтой бус байгаа нь бидний судалгаагаар харагдаж байна. Өөрөөр хэлбэл, нийт 409 хүмүүсийн дийлэнх буюу 264 /57,4%/ оролцогч гадаад хэл сурч эхэлсэн нас хэл сурхамжилтанд нөлөөлсөн үү гэсэн асуултанд зарим талаар нөлөөлсөн гэсэн байхад 135 буюу 29,4 хувь нь л гадаад хэл сурч эхлэхэд нас маш их хэмжээгээр нөлөөлсөн гэж хариулцгаажээ. Энэ нь дунд сургуулийн сурагчдын 32,6% болон оюутнуудын дөнгөж 26% нь бага насандaa сурсан бол илүү их амжилт үзүүлэх байсан гэж үзэцгэсжээ.

## Хүснэгт 2.9

Судалгаанд хамрагдсад хэдэн насандaa гадаад хэл сурч эхлэх байсан бэ?

Хэдэн насандaa сурч эхлэх байсан бэ?	Дунд сургуулийн суралцагсад		Их Дээд сургуулийн оюутнууд		Англи хэлний багш нар	
	Fre quency	Valid Percent	Fre quency	Valid Percent	Fre quency	Valid Percent
Бага насандaa	37	40,2				
Өсвөр насандaa	7	7,6	190	66,9	17	51,5
Сурсан нас минь боломжийн	48	52,2	91	32,0	16	48,5
Идэр насандaa			3	1,1		
Totals	92	100	284	100	33	100

Харин судалгаанд хамрагдсад хэдэн насандaa гадаад хэл сурч эхлэх байсан бэ асуултанд дунд сургуулийн сурагчдын 52,2% нь сурсан насандaa сэтгэл хангалуун гэж хариулсан байхад, оюутнуудын 66,9%, багш нарын 51,5% нь өсвөр насандaa сурсан бол дээр байсан гэсэн байна. Эндээс харахад бага насандaa гадаад хэлийг илүү амжилттай сурдаг гэсэн үзэл потлогдохгүй байгаа бөгөөд нийт суралцагчдын **60 –с дээш хувь нь өсвөр насандaa сурх нь хамгийн тохиromжтой** гэсэн байна.

## Хүснэгт 2.10

Оюутан болон багш нар / 30-с дээш насандaa гадаад хэл сурахад үүсэх хүндэрлүүд/

Оюутнуудын Хариулт	Fre quency	Valid Percent	Багш нарын хариулт	Fre quency	Valid Percent
Авиан дуудлага	99	34,9	Авиан дуудлага	13	39,4
Хэл зүйн дүрэм	73	25,7	Хэл зүйн дүрэм	2	6,1
Үг хэллэг	45	15,8	Үг хэллэг	3	9,1
Үг хэлийг ашиглах ерөнхий чадвар	47	16,5	Үг хэлийг ашиглах ерөнхий чадвар	5	15,2
Авиан дуудлага, үг хэлийг ашиглах ерөнхий чадвар	9	3,2	Хэцуу асуудал гарахгүй	4	12,1
Үг хэллэг, үг хэлийг ашиглах ерөнхий чадвар	3	1,1	Авиан дуудлага, хэл зүйн дүрэм	4	12,1
Авиан дуудлага, үг хэллэг	3	1,1	Авиан дуудлага, үг хэллэг	1	3,0
Хэл зүйн дүрэм, үг хэллэг	4	1,4	Авиан дуудлага, үг хэлийг ашиглах ерөнхий чадвар	1	3,0
Мэдэхгүй байна	1	,4			
Total	284	100,0	Total	33	100,0

Оюутнуудын үзэж байгаагаар 30-с дээш насанд гадаад хэл сурхад авиан дуудлага / 99 – 34.9% / болон хэл зүйн дүрэм /73 буюу 25.7% / хамгийн бэрхшээлтэй байдаг гэсэн бол багшинарын хариултаас харахад 39.4% нь авиан дуудлага сурхад хэцүү байдаг бол 5 багшинаар 15.2% нь уг хэлийг ашиглах өрөнхий чадвар буурдаг гэсэн байна. 4 багшинаар хэцүү асуудал гарахгүй гэсэн нь ихээхэн сонирхол татаж байгаа юм. Насанд хүрэгсэдэд авиан дуудлага хэцүү асуудал болдог шалтгаан нь магадгүй тэдний нүүр амын булчингийн хөдөлгөөнүүдтэй холбоотой байж болох ч өдөр тутам хөргэлэдэг эх хэлний зарим авиануудыг онцгой маягаар дууддаг зуршилтай ч холбон үзэж болох юм. Энэ насны бүлгийнхэн хэлийг тогтоон систем гэж ойлгодог бөгөөд хэл зүйн дүрмийг ухамсартайгаар сурч хэрэглэх хандлагатай байдгаас хэл зүйн дүрмүүдийг сурхад хүндрэл бага гардаг. Уг хэлийг ашиглах өрөнхий чадвар гэдэг нь англи хэлээр унших, бичих, ярих болон сонсох чадварыг хамтад нь эзэмшиж сурна гэсэн үг юм. Уг хэллэг насанд хүрэгсэдийн хувьд бэрхшээлтэй асуудлын иэг болж байгааг 47 оюутаны буюу 15.8% нь хариулт харуулж байна. Ялангуяа Англи хэлний ихэих үг хэллэг давхар утгатай, утглагыг /prepositions/, хэлцүүлгүүг /phrasal verbs/ ихтэй байдгаас суралцагсдад төвөгтэй байдлыг үүсгэдэг байна.

Хүснэгт 2.11

Дунд сургуулийн сурагчдын үзэж байгаагаар 18-с дээш насанд гадаад хэл сурхад үүсчх асуудлууд

Дунд сургуулийн сурагчдын хариулт	Frequency	Valid Percent
<b>Авиан дуудлага</b>	<b>38</b>	<b>41,3</b>
Хэл зүйн дүрэм	10	10,9
Үг хэллэг	9	9,8
<b>Үг хэлийг ашиглах өрөнхий чадвар</b>	<b>24</b>	<b>26,1</b>
Авиан дуудлага, үг хэллэг	9	9,8
Байхгүй	2	2,2
Total	92	100,0

Дунд сургуулийн сурагчдын хувьд 18-с дээш насанд хүрсэн гэж үзэгдэх бөгөөд гадаад хэл сурхад авиан дуудлага /38 сурагч буюу 41.3% /, уг хэлийг ашиглах өрөнхий чадвар / 24 сурагч буюу 26.1% / гэж хариулсан нь оюутнуудын болон багшинарын хариулттай ойролцоо байгаа нь бидний таамаглал зөв болохыг харуулж байна.

Хүснэгт 2.12

Гадаад хэл сурхад амжилт үзүүлэх тодорхой үе гэж байдаг бол хэдэн нас вэ?

Дунд сургуулийн сурагчид	Frequency	Valid Percent	Оюутнууд	Frequency	Valid Percent
4-7	12	13,0	4-7	12	4,2
8-14	21	22,8	8-14	45	15,8
15-19	16	17,4	15-19	62	21,8
20+	1	1,1	20+	42	14,8
Аль ч насандаа	6	6,5	Аль ч насандаа сурч болно	8	2,8
Бага насандаа	14	15,2	Бага насандаа	21	7,4
Мэдэхгүй	1	1,1	мэдэхгүй байна	2	,7
Total	92	100,0	Total	284	100,0

Багшинаар	Frequency	Valid Percent
4-7	1	3,0
8-14	4	12,1
15-19	9	27,3
20+	9	27,3
Аль ч насандаа	2	6,1
Бага насанаас нь	5	15,2
Total	33	100,0

Бидний судалгааны гол зорилго бол гадаад хэл зааж эхлэх хамгийн тохиромжтой насны бүлгийг тогтоон бүх торийн өмчтэй болон хувийн хэвшлийн сургуулиудад тодорхой наснаас англи хэлийг зааж хэвшүүлэх ажлыг онол- практикын үүдиэс батлах явдал юм.

Иймд нийт судалгаанд оролцогсдын хувьд хамгийн тохиромжтой насны бүлгийг юу гэж үзэж байгааг задгай асуулгаар авсан нь янз бүрийн насны бүлгийг үүсгэх шалтгаан болсон. Дунд сургуулийн нийт 92 сурагчдаас 35 буюу 38% нь гадаад хэлийг 8-с 19 насны хооронд заавал үр дүнтэй гэж үзэж байхад, 74 оюутнууд буюу 26.1% нь 6-20 насанд, 62 /21.8% / оюутан ёсвор насанд буюу 15-19 нас хамгийн тохиромжтой нас гэж үзжээ. Сонирхолтой хариултыг 42 оюутан 14.8% 20-с дээш насанд ч гэсэн гадаад хэлийг амжилттай сурна гэсэн нь насанд

хүрэгсэд хэл сурх өөрсдийн зорилго, арга барилтай, өөрсдийн оюун ухааны ухамсарын үйл ажиллагаанд тулгуурлан хэл сурдаг учраас ихэнхдээ амжилттай суралцдаг болохыг харуулж байна. Англи хэлний багш нарын хувьд 8-19 болон 6-20 насны хооронд гэсэн хариулт ижил хувийг /27.3%/ эзэлсэн байна.

**Ном зүй:**

Д. Чимгээ *SPSS for Windows Хэрэглэгчийн гарын авлагы* Улаанбаатар 2008  
Д.Энхбаатар *Microsoft Excel 2003-н томъёо, функцийн* Улаанбаатар 2007  
K. O' Sullivan *English Language Development. Third Education Development Project* Ulaanbaatar 2008